# ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН БАТХУЯГ ОВОГТОЙ ЭРДЭНЭМӨНХИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**НЭГ.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах (Хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго) | | | | | | | |
| Зорилт 3. Нийслэлийн төсөвт байгууллагуудын удирдлагатай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэх (НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоол) | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ: 2.3.1 Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах | Хуулийн этгээдийн тоо, Үнэлгэдсэн байдал | Өмч эзэмшлийн гэрээний 2022 оны биелэлтийг түүвэрчилсэн байдлаар 10 байгууллагын гэрээг дүгнэж, "Бүрэн хангалттай"- 4 "Хангалттай" – 4 "Ажил сайжруулах" -2 үнэлгээ авсан. | -Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагууда ас түүвэрчилсэн байдлаар 20 байгууллагын гэрээг дүгнэнэ. -Төлөвлөсөн хуваарийн дагуу гэрээ дүгнэн дүнгийн нэгтгэл, илтгэх хуудсыг боловсруулсан байна. -Гэрээний дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам"-ын дагуу Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулах тухай албан бичгийг холбогдох 20 агентлагуудад албан бичгээр хүргүүлсэн.<br>Чингэлтэй дүүргийн нийт 22 төсөвт байгууллагуудаас "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" дүгнэсэн дүнгээр нийслэлийн төр захиргааны байгууллага 2, Чингэлтэй дүүргийн төр захиргааны байгууллага 2, 4 сургууль, 8 цэцэрлэг, 4 эрүүл мэндийн төв, 2 Нийслэлийн өмчит төсөвт үйлдвэрийн газар тус тус хамрагдав. "Бүрэн хангалттай" үнэлгээ 4 байгууллага, "Хангалттай" үнэлгээ 14 байгууллага, "Ажил сайжруулах" үнэлгээ 3 байгууллага авч дүгнэгдсэн. | I-II | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэлэлцүүлнэ. | | | |
| 2. | Арга хэмжээ: 2.3.2 НИТХТ-ын 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах | -Хуулийн этгээдийн тоо<br>-Гэрээний тоо | "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулах тухай албан бичгийг 104 байгууллагад хүргүүлсэн. | ЧД-ийн төсөвт 106 байгууллагын удирдлагатай "Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулах ажлыг зохион байгуулна. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам"-ын дагуу Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулах тухай албан бичгийг Чингэлтэй дүүрэг болон холбогдох 20 агентлагид 2024.02,22-ны өдрийн 3/289 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тайлант хугацаанд 104 албан байгууллагаас 102 байгууллага Өмч эзэмшлийн гэрээг байгуулсан. Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газар, Дагуул хот эдийн засгийн тусгай бүсийн газар татан буугдсан тул гэрээ байгуулаагүй. | I-II | 100% |
| Зорилт 5. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн хөдөлгөөн түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах, хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавих зорилт (НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоол) | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ: 2.5.1 Нийслэлийн Засаг даргын хөрөнгө оруулалттай холбоотой 2024 оны хүлээн авсан захирамжуудыг үндэслэн төсөл арга хэмжээг хөрөнгийн эх үүсвэрээр ангилан, судалгаар гаргах | -Төсөл, арга хэмжээний тоо, мөнгөн дүн | НЗД-ын 2023 оны захирамжаар ЧД-т хэрэгжүүлэх нийт 1922,9 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:<br>-НТХО – 354,7 сая төгрөгийн 3 ажил,<br>-ОНХС- 307,9 сая төгрөгийн 2 ажил,<br>-УТХО- 1260,3 сая төгрөгийн 9 ажил, | Шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэсэн тухай мэдээллийг судалгаанд нэгтгэсэн байна. | Захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон гэрээтүүлэг, нийтийн эзэмшлийн тохижилт, засварыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт 1,922,9 сая төгрөгийн 14 ажлын дүнд бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон 8 албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 ажил, нийт 1260,3 сая төгрөг<br>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 ажил, нийт 354,7 сая төгрөг<br>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 ажил, 307,9 сая төгрөг<br>- 258 дугаар цэцэрлэгийн барилгын засвар /ЧД, 11 дүгээр хороо/-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/735 тоотоор 258-р цэцэрлэгт,<br>- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 31 дүгээр цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн засвар (ЧД, 9 дүгээр хороо)-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/734 тоотоор | I-IV | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 31-р цэцэрлэгт,<br>- "Барилга, дээврийн засвар (Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо, 155 дугаар цэцэрлэг)-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/732 тоотоор 155-р цэцэрлэгт,<br>- Спорт заалны засвар болон дээврийн засвар (Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, 24 дүгээр сургууль)-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/732 тоотоор 24-р сургуульд,<br>- Офицерын ордон автобусны буудлын тохижуулах ажил /БЗД, 13-р хороо/, Цагдаагийн академи автобусны буудлын тохижилтын ажил /БЗД, 8-р хороо/-ыг НӨХГ-ын 2024.05.28-ны 3/963 тоотоор Нийслэлийн Нийтийн тээврийн газарт,<br>НЕБ-ын 72 дугаар сургуулийн тохижилт, засварын ажлыг НӨХГ-ын 2024.05.28-ны 3/953 тоотоор тус сургуульд,<br>- НЕБ-ын 23 дугаар сургууль орчмын явган хүний зам засварлах ажил, АШУҮИС-ийн орчмын явган хүний зам засварлах ажлыг НӨХГ-ын 2024.05.28-ны 3/952 тоотоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт,<br>- Цэцэрлэг сургуулиудын гадна талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажлыг НӨХГ-ын 2024.09.27-ны 3/1653 тоотоор 31, 70, 124, 291 дүгээр цэцэрлэг, 37, 50 дугаар сургуульд хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан. | | |
| 4. | Арга хэмжээ: 2.5.2<br>Төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд баригдаж ашиглалтад орсон барилга байгууламж, бий болсон тээврийн хэрэгсэл, тохижилтын ажлуудыг нийслэлийн өмчид буюу | -Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг | Тайлант хугацаанд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр шинээр бий болсон 21 байгууллагын нийт 3,300.0 сая төгрөгийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид | -Шинээр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэнэ. | Тайлант хугацаанд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 54 байгууллагын 3,348.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна. Үүнд:<br>НЗД-ын захирамжаар 3 байгууллагын 9 автомашиныг 524,4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.<br>Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 2 байгууллагын нийт 240,5 сая төгрөгийн өртөгтэй 3 автомашиныг НЗД-ын 2024 оны А/217 дугаар захирамжаар, Цагдаагийн ерөнхий газар, Киа моторс Монгол ХХК-ийн хамтарсан Санхүүгийн гэрээгээр худалдан авсан нийт 283,9 төгрөгийн өртөгтэй 6 автомашиныг НЗД-ын 2024 оны А/217 дугаар захирамжаар бүртгэсэн.<br>Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон нийт 2,823,8 сая төгрөгийн | I-IV | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийслэлийн өмчит төсөвт байгууллагын бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах, | | бүртгэхээр холбогдох шийдвэрийг гаргуулан зээмшигч байгууллагуудад хүргүүлж ажилласан. | | эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар бүртгэж, тушаалын хуулбарыг 51 байгууллага ирүүлсэн.<br>Үүнд: компьютер, принтер, хөгжим, угаалгын машин гэх мэт машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад дансны хөрөнгө байна. | | |
| 5. | Арга хэмжээ: 2.5.3 Хандив бэлэглэл, буцалтгүй тусламж, зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон эд хөрөнгийг холбогдох журмын дагуу нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах | -Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг<br>-ҮХХХК-ын хурлын шийдвэр | ҮХХХК-ийн 6 удаагийн хурлаар давхардсан тоогоор **11** байгууллагын **3,330,8** сая төгрөгийн хөрөнгийг бүртгэх шийдвэрийг гаргуулсан. | ЧД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хандив, тусламжаар бий болсон эргэлтийн бус хөрөнгийг ҮХХХК-ийн хуралд танилцуулан шийдвэрлүүлнэ. | Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн 6 байгууллагын 291,2 сая төгрөгийн эд хөрөнгийг шийдвэрлэсэн байна. Үүнд:<br>Төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн Замын хөгжлийн газарт 204,0 сая төгрөгийн хөрөнгийг Газрын даргын 2024.09.30-ны өдрийн А/313 дугаар тушаалаар,<br>Дэлхийн зөн олон улсын байгууллага, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ардын Засгийн газар, Монголын улаан загалмайн нийгэмлэгээс хандивласан нийт 87,1 сая төгрөгийн хөрөнгийг НЗДТГ болон 221, 246 дугаар цэцэрлэгт Газрын даргын 2024,02,15-ны өдрийн А/21, 2024.11.04-ний өдрийн А/431, 2024.11.11-ний өдрийн А/455 дугаар тушаалаар бүртгэсэн байна. | I-IV | 100% |
| 6. | Арга хэмжээ: 2.5.4 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг акталж, данснаас хасах | -Акталсан барилгын тоо<br>-Мөнгөн дүн сая.төг | НИТХТ-ын тогтоол, НЗД-ын захирамжийн дагуу тооллогын мөрөөр маргаантай байсан **1** байгууллагын нийт **77,4** сая төгрөгийн барилгыг данснаас хасуулах шийдвэр гаргуулав. | НИТХТ-ийн тогтоол, НЗД-ын захирамжаар нийслэлийн өмчийн бүртгэлээс хассан - 1315,3 сая төгрөг | Тайлант хугацаанд Чингэлтэй дүүргийн нийслэлийн өмчит 3 байгууллагын ашиглалтын шаардлага хангахгүй болсон 1315,3 сая төгрөгийн барилга байгууламжийг данснаас хасч, актлах асуудлыг судлан, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан нийслэлийн өмчийн бүртгэлээс хасуулах шийдвэрийг гаргуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Үүнд:<br>108 дугаар цэцэрлэгийн хуучин барилгыг буулгаж, шинээр барилга барих болсонтой холбогдуулан тус цэцэрлэгийн барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай тогтоолын төслийг НЗД-ын 2024.09.18-ны 01/5342-р албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.19-ны 115-р тогтоол, НЗД-ын 2024.11.04 А/1272 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.11 3/1924 дугаар албан бичгийг 108-р цэцэрлэгт,<br>23 дугаар сургуулийн Спорт заалны барилгыг | I-IV | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | буулгаж, шинээр усан бассейн бүхий спорт заал барих болсонтой холбогдуулан НЕБ-ын 23-р сургуулийн спорт заалны барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай асуудлыг НЗД-ын 2024.09.24-ний өдрийн 01/5465 тоот албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.24-ний 133-р тогтоол, НЗД-ын 2024.11.04 А/1273 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.19 З/1988 дугаар албан бичгийг 23-р сургуульд хүргүүлсэн.<br>74 дүгээр цэцэрлэгийн хуучин барилгыг буулгаж, шинээр барилга барих болсонтой холбогдуулан тус цэцэрлэгийн барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай НИТХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг НЗД-ын 2024.11.05-ны өдрийн 01/6241 дүгээр албан бичгээр хүргүүлж НИТХ-д хүргүүлж, 2024.11.29-нд хурлаар хэлэлцүүлсэн байна.<br>Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг үнэлэн, худалдан борлуулах дүн 35,8 сая төгрөгөөс 13,8 сая төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. | | |
| 7. | Арга хэмжээ: 2.5.6 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгийг акталж, данснаас хасах | -Хөрөнгийн мөнгөн дүн сая.төг<br>-ҮХХХК-ын хурлын шийдвэр | ҮХХХК-ийн 7 удаагийн хурлаар давхардсан тоогоор **26** байгууллагын нийт **2,267.5 сая** төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хасуулах шийдвэр гаргуулав | ЧД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ашиглалтын шаардлага хангахгүй эргэлтийн бус хөрөнгийг ҮХХХК-ийн хурлаар шийдвэрлүүлнэ. | Тайлангийн хугацаанд ашиглалтын шаардлага хангахгүй болсон, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 2060,0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасуулах Чингэлтэй дүүргийн 23 байгууллагын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.<br>Хурлаас нийт 684,9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулахаар шийдвэрлэж, 5,5 сая төгрөгөөр үнэлж, нийслэлийн төсөвт 1,657,200 төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна. | I-IV | 100% |

75

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Арга хэмжээ: 2.5.7 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу барилга байгууламж, тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх | -Балансаас балансад шилжсэн хөрөнгийн тоо<br>-Мөнгөн дүн сая.төг | ҮХХХК-ийн 5 удаагийн хурлаар **24** байгууллагын нийт **8,713.4** сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий илүүдэлтэй байгаа болон ашиглахгүй байгаа эд хөрөнгийг 32 байгууллагад балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргуулав. | ЧД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу эд хөрөнгө балансаас балансад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ | Дээрх ажлын хүрээнд 47 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 17 тэрбум төгрөгийн хөрөнгийг НИТХ-ын тогтоол, НЗД-ын захирамж болон НӨХГ-ын даргын тушаалаар барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг холбогдох байгууллагуудын баланст шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлсэн байна. Үүнд:<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор: - 16,129.8 сая төгрөг<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Хангарьд ордны барилгыг Монгол Улсын дээд шүүхэд шилжүүлэх тухай албан бичгийг ирүүлсний дагуу НЗД-ын 2024.09.12-ны өдрийн 01/5222 дугаар албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.19-ний 121-р тогтоол, НЗД-ын 2024.11.01-ний өдрийн А/1257 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.04-ний өдрийн 3/1856 дугаар албан бичгийг Шүүхийн ерөнхий зөвлөлд, 2024.11.04-ний өдрийн 3/1863 дугаар албан бичгүүдийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газруудад хүргүүлсэн.<br>Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас 2,3 тэрбум төгрөгийн өртөгтэй эд хөрөнгийг Цагдаагийн Ерөнхий газарт балансаас баланст шилжүүлэх хүсэлт ирүүлсний дагуу НИТХ-ын тогтоол, танилцуулгыг бэлтгэн, НЗД-ын 2024.09.18-ны 01/5341 дүгээр албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.24-ний 132-р тогтоол, НЗД-ын 2024.11.14-ний өдрийн А/1340 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.19-ний өдрийн 2/1981, 1982, 1983, 1984, 1985, 1986, 1987 дугаар албан бичгүүдийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газруудад хүргүүлсэн.<br>Нийслэлийн Засаг даргын захирамжаар: - 99,9 сая төгрөг<br>Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас Нийслэлийн Төр захиргааны Авто баазад бага оврын автобус шилжүүлэх хүсэлт ирүүлсний дагуу Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл, танилцуулга бэлтгэн, НЗД- | I-IV | 100% |

75

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ын 2024.11.04 А/1296 дугаар захирамжийг гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.11-ний өдрийн 3/1925, 3/1926 дугаар албан бичгүүдийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Төр захиргааны авто баазад хүргүүлсэн.<br>ҮХХХК-ын хурлаар 975,6 сая төгрөг<br>Илүүдэлтэй хөрөнгийг шаардлагатай байгууллагын балансад шилжүүлэх 44 байгууллагын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна. Үүнд 577,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 152,2 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 228,4 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгө, 17,8 сая төгрөгийн бусад хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэж, Газрын даргын тушаалыг гаргуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | | |
| 9. | Арга хэмжээ: 2.5.8 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу эд хөрөнгийг данснаас дансанд шилжүүлж, залруулга хийх асуудлыг шийдвэрлэх | -Хөрөнгийн мөнгөн дүн сая.төг<br>-ҮХХХК-ын хурлын шийдвэр | ҮХХХК-ийн 2 удаагийн хурлаар **1** байгууллагын нийт **503,3 сая** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг данс хооронд шилжүүлэх шийдвэр гаргуулав. | ЧД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг ҮХХХК-ийн хурлаар шийдвэрлүүлнэ | Тайлангийн хугацаанд хөрөнгө данснаас дансанд шилжүүлэх 2 байгууллагын нийт 186,9 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг судлан боловсруулж "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. | I-IV | 100% |
| 10. | Арга хэмжээ: 2.5.9 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу эд хөрөнгийг дахин үнэлэх | -Дахин үнэлсэн хөрөнгийн дүн сая.төг | ҮХХХК-ийн 7 удаагийн хурлаар 9 байгууллагын нийт 2,790.4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг 1,051.2 сая төгрөгөөр дахин | ЧД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хөрөнгө дахин үнэлэх асуудлыг ҮХХХК-ийн хурлаар шийдвэрлүүлнэ | Элэгдлээрээ эртгээ нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн байгууллагын ӨХБЗХ-ын шийдвэрээр цаашид ашиглах жилийг тогтоож, дахин үнэлсэн хөрөнгийг "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл олгосон. Үүнд :<br>Чингэлтэй дүүргийн 5 байгууллагын нийт **1155,7** сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй хөрөнгийг **326,8** сая төгрөгөөр дахин үнэлсэн болно. | I-IV | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үнэлэх албан тоот гаргуулав. | | | | |
| 11. | Арга хэмжээ: 2.5.13 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, мэдээллийн санг бүрдүүлэх *(Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль)* | -Мэдээллийн сан баяжигдах | Нийт 105 хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, үндсэн хөрөнгийн тодруулгыг шалган тулгалт хийв. | ТӨБЗГ-аас ирүүлсэн маягт, аргачлалын дагуу 2023 оны санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэн хүргүүлсэн байна. | ТӨБЗГ-аас нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг программаар хүлээн авах болсонтой холбогдуулан сургалтыг 2024.02.23-ны өдөр хийсэн сургалтад ЧД-ийн 106 төсөвт байгууллагад зар тараасан болно.<br>Нийслэлийн төр захиргааны байгууллага 22, Чингэлтэй дүүргийн төр захиргааны байгууллага 14, 18 сургууль, 39 цэцэрлэг, 16 эрүүл мэндийн нэгдэл, 6 сан тус тус хамрагдаж, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлангийн нэгтгэл, тодруулгыг шалган тулгалт хийж, "Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны цахим систем" –ээр нэгтгэв. Мөн хөрөнгийн бүртгэл мэдээллийн болон захиргааны статистикийн нийт 17 маягтаар жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээг хүлээн авав. | I-IV | 100% |
| Зорилго 3. Байгууллагын захиргаа, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах (Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх) | | | | | | | |
| Зорилт 1. Байгууллагын захиргаа, хүний нөөцийн эрхэлсэн асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилт | | | | | | | |
| 12. | Арга хэмжээ: 3.1.10 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих | -Тарьсан модны тоо<br>-Албан хаагчдын оролцоог хангуулах | 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд Налайх дүүргийн "Шинэ-Налайх" цэцэрлэгт хүрээлэнд 5 шинэс модны байгууллагын албан хаагчдын хамт суулгасан. | Мод тарих арга хэмжээ 1-2 удаа оролцоно. | "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Налайх дүүргийн "Шинэ-Налайх" цэцэрлэгт хүрээлэнд мод тарих нээлтийн арга хэмжээнд оролцон өөрсдийн зардлаар шинэс модны суулгац авч, хуваарилсан талбайд суулгасан. | I-IV | 100% |
| 13. | Арга хэмжээ: 3.1.11 2024 оны "Тохижилт бүтээн байгуулалт"-ын жил төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу байгууллагын хэмжээнд арга хэмжээ шинээр санаачлан ажиллахад | - | -Төлөвлөгөөний хэрэгжилтийн ханган ажилласан байх | Нийслэлийн батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээ төлөвлөн ажилласан байна. | -2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан хуваарийн дагуу Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэлх талбай болон Байгууллагын оффисын дотор ажлын байр, өрөө тасалгаанд тус тус их | I-IV | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцох | | | | цэвэрлэгээ хийсэн. | | |
| 14. | Дэд арга хэмжээ<br>Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх | -Цаг хугацаандаа шийдвэрлэх | 100% | | Тайлант хугацаанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 314 албан бичиг хүлээн авснаас 314 албан бичгийг хуулийн хугацаанд нь хариуг нь өгч шийдвэрлэсэн байна. | I-IV | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан огноо | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Нэмэлт арга хэмжээ 1. "Мэргэжлийн хяналтын газрыг татан буулгасантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023.01.31-ний өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулагдсан Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэгт орж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор "Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022.12.31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023.01.31-ний өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулагдсан тус газрын балансад бүртгэлтэй хөрөнгүүдийг хүлээн авах, шилжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж 2024 онд тус Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцсэн байна.<br>Нийслэлийн Өмчийн харилцааны газарт НӨХГ-ын даргын 2024.02.15-ны өдрийн А/22 дугаар тушаалаар 25,863,330 төгрөгийн, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-т НӨХГ-ын даргын 2024.07.09-ны өдрийн А/206 дугаар тушаалаар 5,475,394.15 төгрөгийн, Нийслэлийн Өмчийн харилцааны газарт НӨХГ-ын даргын 2024.07.09-ны өдрийн А/224 дүгээр тушаалаар 95,280,642.20 төгрөгийн, нийт 126,619,366.35 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас balanct шилжүүлсэн байна.<br>НМХГ-ын 10,029,544.6 төгрөгийн актлаж, данснаас хасах хөрөнгийг 2024.05.30-ны өдөр очиж, татан төвлөрүүлж, ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлж, эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай 2024,07,09-ний өдрийн А/223 дугаар тушаал гаргуулсан.<br>Мөн 2024.06.27-ны өдөр НМХГ-ын балансt бүртгэлгүй байсан хуучин 22-ын товчоонд байрлалтай журмын хашаанд хураагдан, хадгалагдаж буй хөрөнгийн байдлыг биет байдлаар үзэн танилцаж, акт үйлдэж Ажлын хэсэг | 01.01<br>07.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүлээн авсан.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавих үүрэг бүхий нийслэлийн зөвлөлд тус бүртгэлгүй хөрөнгийг хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээний компаниар үнэлүүлж нийслэлийн өмчид бүртгэх, худалдан борлуулах, Улсын орлого болгох саналыг хүргүүлж 2024.07.18-ны өдрийн 3/1312 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>Энэхүү Ажлын хэсгийн татан төвлөрүүлсэн хөрөнгүүдээс зарим хөрөнгүүдийг холбогдох байгууллагуудад шилжүүлж, үлдсэн 22-ын хашаанд хадгалагдаж буй хөрөнгийг Ажлын хэсэг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэст 2024.07.18-ны өдөр актаар, хүлээлгэн өгсөн байна.<br>Тус татан буугдсан газрын хөрөнгийн асуудал эцэслэн шийдвэрлэгдэж хаалтын тайланг гаргаж дууссан болно. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Архивт тус хөрөнгөтэй холбоотой 6 архивын баримтыг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн. | | |
| 2 | Нэмэлт арга хэмжээ 2. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлд орж ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Газрын даргын 2024 оны А/32 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны төлөвлөгөө"-г хэлэлцэн батлуулж, зөвлөлийн ажиллах журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулан 8 удаагийн хуралдаанаар давхардсан тоогоор 17 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. | 01.01<br>12.31 | 100% |
| 3 | Нэмэлт арга хэмжээ 3. Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу татан буугдсан байгууллагын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2024.02.28-ны өдрийн 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024.04.12-ны өдрийн А/423 дугаар захирамжаар Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрыг татан буулгасан. Тус газрын 116,8 сая төгрөгийн хөрөнгийг Бодлогын судалгаа, шинжилгээний төв НТҮГ болон Хот байгуулалт, хотын стандартын газарт шилжүүлж, НӨХГ-ын даргын 2024,07,09-ны өдрийн А/210 дугаар тушаал, 8,8 сая төгрөгийн санхүүгийн програм хангамжийг данснаас хасах шийдвэрийг НӨХГ-ын даргын 2024.07.09-ны өдрийн А/207 дугаар тушаал гаргуулан ажилласан байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024.04.12-ны өдрийн А/422 дугаар захирамжаар Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газрыг татан буулгасан. Тус газрын цаашид ашиглах боломжгүй 128,8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасах тухай НӨХГ-ын даргын 2024.11.11-ний өдрийн А/457 дугаар тушаал гаргуулан ажилласан байна. | 01.01<br>12.31 | 90% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 15. | Дэд арга хэмжээ Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох | Олон нийтийн арга хэмжээнд оролцосон байх | 100% | Танхимаар болон цахимаар суралцана. Сургалтад идэвхитэй оролцож мэдлэг ур чадвараа дээшлүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. | НЗДТГ-аас болон байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд:<br>-Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалт цахим сургалт;<br>-Нийслэлийн түүх, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, чиг үүрэг;<br>-Өөрчлөлтийн менежмент; -MS Excel /дунд шат, ахисан шат/;<br>-Жендерийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо;<br>Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх;<br>-ТӨБЗГын төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын нэгдсэн сургалт зөвлөгөө;<br>-2024.04.25, 05.02, 05.16-ны өдрийн 7:4:10 цахим сургалтуудад хамрагдсан байна. | I-IV | 100% |

**Тайлан гаргасан:**

Мэргэжилтэн ............ /Б.Эрдэнэмөнх/ 2024 12 02

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

# ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ЭРДЭНЭМӨНХИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2024.12.02 Улаанбаатар хот

## НЭГ. НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭДИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН, ХОЛБОГДОХ БУСАД ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэх ажлын талаар:

Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон нийт 5562,3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж байна. Задлаж үзүүлбэл:

1. *НИТХ-ын тогтоолоор бүртгэсэн барилга байгууламж - 0 төгрөг*
2. *НЗД-ын захирамжаар бүртгэсэн тээврийн хэрэгсэл – 524,4 сая төгрөг*

Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 2 байгууллагын нийт 240,5 сая төгрөгийн өртөгтэй 3 автомашиныг НЗД-ын 2024 оны А/217 дугаар захирамжаар, Цагдаагийн ерөнхий газар, Киа моторс Монгол ХХК-ийн хамтарсан Санхүүгийн гэрээгээр худалдан авсан нийт 283,9 төгрөгийн өртөгтэй 6 автомашиныг НЗД-ын 2024 оны А/217 дугаар захирамжаар бүртгэсэн.

3. *ЭБХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө – 291,2 сая төгрөг*

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн 6 байгууллагын 291,2 сая төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх хүсэлтийг ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлж, Газрын даргын 2024,02,15-ны өдрийн А/21, 2024.09.30-ны өдрийн А/313, 2024.11.04-ний өдрийн А/431, 2024.11.11-ний өдрийн А/455 дугаар тушаалууд гаргуулсан.

4. *Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал – 1,922,9 сая төгрөг*

Захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн тохижилт, засварыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт *1,922,9* сая төгрөгийн 14 ажлын дүнд бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон 8 албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9 ажил, нийт 1260,3 сая төгрөг

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 ажил, нийт 354,7 сая төгрөг

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 ажил, 307,9 сая төгрөг

- 258 дугаар цэцэрлэгийн барилгын засвар /ЧД, 11 дүгээр хороо/-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/735 тоотоор 258-р цэцэрлэгт хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 31 дүгээр цэцэрлэгийн барилгын хэсэгчилсэн засвар (ЧД, 9 дүгээр хороо)-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/734 тоотоор 31-р цэцэрлэгт хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.
- "Барилга, дээврийн засвар (Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо, 155 дугаар цэцэрлэг)-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/732 тоотоор 155-р цэцэрлэгт хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.
- Спорт заалны засвар болон дээврийн засвар (Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, 24 дүгээр сургууль)-ын ажлыг НӨХГ-ын 2024.04.22-ны 3/732 тоотоор 24-р сургуульд хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.
- Офицерын ордон автобусны буудлын тохижуулах ажил /БЗД, 13-р хороо/, Цагдаагийн академи автобусны буудлын тохижилтын ажил /БЗД, 8-р хороо/-ыг НӨХГ-ын 2024.05.28-ны 3/963 тоотоор Нийслэлийн Нийтийн тээврийн газарт хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.

- НЕБ-ын 72 дугаар сургуулийн тохижилт, засварын ажлыг НӨХГ-ын 2024.05.28-ны 3/953 тоотоор тус сургуульд хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.
- НЕБ-ын 23 дугаар сургууль орчмын явган хүний зам засварлах ажил, АШУҮИС-ийн орчмын явган хүний зам засварлах ажлыг НӨХГ-ын 2024.05.28-ны 3/952 тоотоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.
- Цэцэрлэг сургуулиудын гадна талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажлыг НӨХГ-ын 2024.09.27-ны 3/1653 тоотоор 31, 70, 124, 291 дүгээр цэцэрлэг, 37, 50 дугаар сургуульд хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг даалгасан.

5. *Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар бүртгэж, тушаалын хуулбараа ирүүлэх – 2,823,8 сая төгрөг*

Хавсралтад заасан нийт 51 байгууллагаас улс, нийслэлийн төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон 2,823,8 сая төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгө /компьютер, принтер, хөгжим, угаалгын машин/-ийг байгууллагын даргын тушаалаар бүртгэж, тушаалын хуулбараа ирүүлсэн байна.

Хөрөнгө данснаас хасч, актлах асуудлын талаар:

Тайлант хугацаанд Чингэлтэй дүүргийн нийслэлийн өмчит байгууллагуудын ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 3320,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасч, актлах асуудлыг судлан, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан нийслэлийн өмчийн бүртгэлээс хасуулах шийдвэрийг гаргуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

1. НИТХТ-ийн тогтоол, НЗД-ын захирамжаар нийслэлийн өмчийн бүртгэлээс хассан - 1375,3 сая төгрөг
- 108 дугаар цэцэрлэгийн хуучин барилгыг буулгаж, шинээр барилга барих болсонтой холбогдуулан тус цэцэрлэгийн барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай тогтоолын төслийг НЗД-ын 2024.09.18-ны 01/5342-р албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.19-ны 115-р тогтоол, НЗД-ын 2024.11.04 А/1272 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.11 3/1924 дугаар албан бичгийг 108-р цэцэрлэгт хүргүүлсэн.
- 23 дугаар сургуулийн Спорт заалны барилгыг буулгаж, шинээр усан бассейн бүхий спорт заал барих болсонтой холбогдуулан НЕБ-ын 23-р сургуулийн спорт заалны барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай асуудлыг НЗД-ын 2024.09.24-ний өдрийн 01/5465 тоот албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.24-ний 133-р тогтоол, НЗД-ын 2024.11.04 А/1273 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.19 3/1988 дугаар албан бичгийг 23-р сургуульд хүргүүлсэн.
- Хуучин барилгыг буулгаж, шинээр барилга барих болсонтой холбогдуулан ЧД-ийн 74-р цэцэрлэгийн барилгын нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай НИТХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг НЗД-ын 2024.11.05-ны өдрийн 01/6241 дүгээр албан бичгээр хүргүүлж НИТХ-р хэлэлцүүлсэн. Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг үнэлэн, худалдан борлуулах дүн 35,8 сая төгрөгөөс 13,8 сая төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.

2. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын хуралд оруулан шийдвэрлүүлсэн асуудлууд – 2,060.0 сая төгрөг

Тайлангийн хугацаанд ашиглалтын шаардлага хангахгүй болсон, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөдлөх хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасуулах Чингэлтэй дүүргийн 23 байгууллагын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Хурлаас нийт 684.9 сая төгрөгийн хөрөнгийг

худалдан борлуулахаар шийдвэрлэж, 5,5 сая төгрөгөөр үнэлж, нийслэлийн төсөвт 1,657,200 төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Хөрөнгө худалдан авах талаар:

Тайлант хугацаанд хөрөнгө худалдан авах зөвшөөрөл хүссэн албан бичиг ирээгүй.

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх талаар:

Дээрх ажлын хүрээнд 4 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 17,2 тэрбум төгрөгийн хөрөнгийг НИТХ-ын тогтоол, НЗД-ын захирамж болон НӨХГ-ын даргын тушаалаар барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг холбогдох байгууллагуудын баланст шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлсэн байна. Үүнд:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор: - 16,129,8 сая төгрөг

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Хангарьд ордны барилгыг Монгол Улсын дээд шүүхэд шилжүүлэх тухай албан бичгийг ирүүлсний дагуу НЗД-ын 2024.09.12-ны өдрийн 01/5222 дугаар албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.19-ний 121-р тогтоол, НЗД-ын 2024.11.01-ний өдрийн А/1257 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.04-ний өдрийн 3/1856 дугаар албан бичгийг Шүүхийн ерөнхий зөвлөлд, 2024.11.04-ний өдрийн 3/1863 дугаар албан бичгүүдийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газруудад хүргүүлсэн.
- Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас 2,3 тэрбум төгрөгийн өртөгтэй эд хөрөнгийг Цагдаагийн Ерөнхий газарт балансаас баланст шилжүүлэх хүсэлт ирүүлсний дагуу НИТХ-ын тогтоол, танилцуулгыг бэлтгэн, НЗД-ын 2024.09.18-ны 01/5341 дугаар албан бичгээр өргөн барьж, НИТХ-ын 2024.09.24-ний 132-р тогтоол, НЗД-ын 2024.11.14-ний өдрийн А/1340 дугаар захирамж гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.19-ний өдрийн 2/1981, 1982, 1983, 1984, 1985, 1986, 1987 дугаар албан бичгүүдийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газруудад хүргүүлсэн.

2. Нийслэлийн Засаг даргын захирамжаар: - 99,9 сая төгрөг

- Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас Нийслэлийн Төр захиргааны Авто баазад бага оврын автобус шилжүүлэх хүсэлт ирүүлсний дагуу Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл, танилцуулга бэлтгэн, НЗД-ын 2024.11.04 А/1296 дугаар захирамжийг гаргуулан НӨХГ-ын даргын 2024.11.11-ний өдрийн 3/1925, 3/1926 дугаар албан бичгүүдийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Төр захиргааны авто баазад хүргүүлсэн.

3. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцах комиссын хуралд оруулан шийдвэрлүүлсэн асуудлууд: - 975,6 сая төгрөг

- Илүүдэлтэй хөрөнгийг шаардлагатай байгууллагын балансад шилжүүлэх 44 байгууллагын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж, 975.6 сая төгрөгийн хөрөнгө, үүнд 577.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 152.2 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 228.4 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгө, 17.8 сая төгрөгийн бусад хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэж, Газрын даргын тушаалыг гаргуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Хөрөнгө данснаас дансанд шилжүүлэх талаар: - 186,9 сая төгрөг

-Тайлангийн хугацаанд хөрөнгө данснаас дансанд шилжүүлэх 2 байгууллагын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.

Хөрөнгө дахин үнэлэх талаар: - 326,8 сая төгрөг

- Тайлангийн хугацаанд үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлэх хүсэлтийг 5 байгууллага ирүүлсний дагуу ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлж, Газрын даргын тушаалыг гаргуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

## ХОЁР. ӨМЧ ЭЗЭМШЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ АЖЛЫН ТАЛААР

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам"-ын дагуу Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг байгуулах тухай албан бичгийг Чингэлтэй дүүрэг болон холбогдох 20 агентлагид 2024.02.22-ны өдрийн 3/289 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар 104 албан байгууллагаас 102 байгууллага Өмч эзэмшлийн гэрээг байгуулсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам", Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/90 дугаар тушаалаар батлагдсан Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсэгт орж ажилласан.

Чингэлтэй дүүргийн нийт 22 төсөвт байгууллагуудаас "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" дүгнэсэн дүнгээр нийслэлийн төр захиргааны байгууллага 2, Чингэлтэй дүүргийн төр захиргааны байгууллага 2, 4 сургууль, 8 цэцэрлэг, 4 эрүүл мэндийн төв, 2 Нийслэлийн өмчит төсөвт үйлдвэрийн газар тус тус хамрагдав. "Бүрэн хангалттай" үнэлгээ 4 байгууллага, "Хангалттай" үнэлгээ 14 байгууллага, "Ажил сайжруулах" үнэлгээ 3 байгууллага авч дүгнэгдсэн.

Чингэлтэй дүүргийн 222 дугаар цэцэрлэг 86 оноо, 24 дүгээр сургууль 90,5 оноо, 154 дүгээр цэцэрлэг 80 оноо, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар 82,5 оноо, Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв 80 оноо авч "Бүрэн хангалттай" үнэлгээ, "Ажил сайжруулах" үнэлгээг Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны "Таны итгэл" ӨЭМТ, 14 дүгээр хорооны "Чин хүслэн" ӨЭМТ-үүд 60 оноо, Чингэлтэй дүүргийн 117 дугаар сургууль 70,5 оноо авч дүгнэгдсэн.

## ГУРАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ТАЛААР:

ТӨБЗГ-аас нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг программаар хүлээн авах болсонтой холбогдуулан сургалтыг 2023.02.23-ны өдөр хийж, ЧД-ийн 109 төсөвт байгууллага болон төслийн нэгжид зар тараасан болно.

Чингэлтэй дүүргийн нийт 109 нийслэлийн өмчит төсөвт байгууллага болон төслийн нэгжийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлангийн нэгтгэл, тодруулгыг шалган тулгалт хийж, "Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны цахим систем" –ээр нэгтгэв. Мөн хөрөнгийн бүртгэл мэдээллийн болон захиргааны статистикийн 17 маягтаар жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээг хүлээн авав.

Үүнд нийслэлийн төр захиргааны байгууллага 22, Чингэлтэй дүүргийн төр захиргааны байгууллага 14, 18 сургууль, 39 цэцэрлэг, 16 эрүүл мэндийн нэгдэл, 6 сан тус тус хамрагдав.

## ДӨРӨВ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Монгол Улсын Засгийн газар, НИТХ, НЗД болон холбогдох дээд байгууллагаас гаргасан тогтоол, захирамж, санамж бичиг, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2021-2024 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулсан.

Тайлангийн хугацаанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 314 албан бичиг хүлээн авснаас 314 албан бичгийг хуулийн хугацаанд нь хариуг нь өгч шийдвэрлэсэн байна.

2023 онд үйл ажиллагааны явцад үүссэн 10 хадгаламжийн нэгжийг бүрдүүлэн архивт актаар хүлээлгэн өгөхөд бэлдсэн.

## ТАВ. БУСАД АЖЛЫН ТАЛААР:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор "Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022.12.31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023.01.31-ний өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулагдсан тус газрын балансад бүртгэлтэй хөрөнгүүдийг хүлээн авах, шилжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж 2024 онд тус Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцсэн байна.

Нийслэлийн Өмчийн харилцааны газарт НӨХГ-ын даргын 2024.02.15-ны өдрийн А/22 дугаар тушаалаар 25,863,330 төгрөгийн, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-т НӨХГ-ын даргын 2024.07.09-ны өдрийн А/206 дугаар тушаалаар 5,475,394.15 төгрөгийн, Нийслэлийн Өмчийн харилцааны газарт НӨХГ-ын даргын 2024.07.09-ны өдрийн А/224 дугээр тушаалаар 95,280,642.20 төгрөгийн, нийт 126,619,366.35 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансaт шилжүүлсэн байна.

НМХГ-ын 10,029,544.6 төгрөгийн актлаж, данснаас хасах хөрөнгийг 2024.05.30-ны өдөр очиж, татан төвлөрүүлж, ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлж, эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай 2024,07,09-ний өдрийн А/223 дугаар тушаал гаргуулсан.

Мөн 2024.06.27-ны өдөр НМХГ-ын балансад бүртгэлгүй байсан хуучин 22-ын товчоонд байрлалтай журмын хашаанд хураагдан, хадгалагдаж буй хөрөнгийн байдлыг биет байдлаар үзэн танилцаж, акт үйлдэж Ажлын хэсэг хүлээн авсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавих үүрэг бүхий нийслэлийн зөвлөлд тус бүртгэлгүй хөрөнгийг хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээний компаниар үнэлүүлж нийслэлийн өмчид бүртгэх, худалдан борлуулах, Улсын орлого болгох саналыг хүргүүлж 2024.07.18-ны өдрийн 3/1312 дугаар албан бичгийг хүргүүлсэн.

Энэхүү Ажлын хэсгийн татан төвлөрүүлсэн хөрөнгүүдээс зарим хөрөнгүүдийг холбогдох байгууллагуудад шилжүүлж, үлдсэн 22-ын хашаанд хадгалагдаж буй хөрөнгийг Ажлын хэсэг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэст 2024.07.18-ны өдөр актаар, хүлээлгэн өгсөн байна.

Тус татан буугдсан газрын хөрөнгийн асуудал эцэслэн шийдвэрлэгдэж хаалтын тайланг гаргаж дууссан болно. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Архивт тус хөрөнгөтэй холбоотой 6 архивын баримтыг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2024.02.28-ны өдрийн 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024.04.12-ны өдрийн А/423 дугаар захирамжаар Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрыг татан буулгасан. Тус газрын 116,8 сая төгрөгийн хөрөнгийг Бодлогын судалгаа, шинжилгээний төв НТҮГ болон Хот байгуулалт, хотын стандартын газарт шилжүүлж, НӨХГ-ын даргын 2024,07,09-ны өдрийн А/210 дугаар тушаал, 8,8 сая төгрөгийн санхүүгийн программ хангамжийг данснаас хасах шийдвэрийг НӨХГ-ын даргын 2024.07.09-ны өдрийн А/207 дугаар тушаал гаргуулан ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024.04.12-ны өдрийн А/422 дугаар захирамжаар Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газрыг татан буулгасан. Тус газрын цаашид ашиглах боломжгүй 128,8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасах тухай НӨХГ-ын даргын 2024.11.11-ний өдрийн А/457 дугаар тушаал гаргуулан ажилласан байна.

Газрын даргын 2024 оны А/32 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны төлөвлөгөө"-г хэлэлцэн батлуулж, зөвлөлийн ажиллах журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулан 8 удаагийн хуралдаанаар давхардсан тоогоор 17 асуудлыг хэлэлцүүлсэн байна.

Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг үнэлэн, худалдан борлуулан 14,9 сая төгрөгийн орлогыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Тайлан бичсэн:
Өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн Б.Эрдэнэмөнх